

ЦАГДААГИЙН ГАЗРЫН 2018 ОНЫ 3 ДУГААР САРЫН 2 ДАХЬ  
ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

№ 9

2018.03.08

Өлгий сум

**Нэг: Аймгийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал.**

Цагдаагийн газарт энэ 7 хоногийн хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 27 гомдол мэдээл ирүүлснийг бүртгэн, шалгасан.

Гэмт хэрэг бүртгэгдээгүй, 27 зөрчил бүртгэгдсэн.

Танхайрах, бусдын биед халдах, гэр бүлийн хүчирхийллэлтэй тэмцэх тухай хууль зөрчих, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчлүүд бүртгэгдсэн байна.

**Хоёр: Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх болон бусад чиглэлээр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ.**

1. Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Баяннуур сумын төвд **“Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд орон нутгийн иргэдийн оролцоо”** сэдэвт сургалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа.

2. Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, хүн худалдаалах, **мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргийн хор уршиг болон садар самуун явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл олгох зорилгоор “Залуучууд ба шинэ төрлийн гэмт хэрэг”** сэдэвт сургалтыг аймгийн Хөгжимт драмын театрт 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр зохион байгууллаа.

Сургалтанд Ховд их сургуулийн Баян-Өлгий аймаг дахь салбар сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн 410 гаруй оюутан, сурагчид хамрагдав.

Сургалтыг зохион байгуулснаар оюутан, сурагчид шинэ төрлийн гэмт хэргийн хор уршигийн талаар мэдээ, мэдээлэлтэй болж, гэмт хэрэгт өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх юм.

3. “Олон нийтийн цагдаагийн дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2, 3.3 дахь хэсэгт заасны дагуу судлагдаж, шаардлага хангаж, сургалтанд хамрагдсан 8 иргэнийг Олон нийтийн цагдаагаар томилж, хөдөлмөрийн гэрээ байгууллаа.

Олон нийтийн цагдаа нар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр ажиллаж, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.6 дахь заалтад заасан зөрчлийг шийдвэрлэх, хариуцсан нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл хийх, гэмт хэрэг, зөрчлийн газар, ул мөрийг хамгаалах, шаардлагатай хүний баримт бичгийг шалгаж, оршин суугаа газрын хаягийг тогтоох, хэв журам сахих талаар иргэн, хуулийн этгээдэд шаардлага тавих болон хууль тогтоомжид заасан бусад эрх эдлэнэ.